



ТӨВ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272262, Факс: 70272192

2024.03.13 № 07/2024
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Төв аймгийн Лүн суманд 3.8 км үерийн далан байгуулах ажлын тендерт оролцогчд компаниудаас дараах асуудлыг тодруулсаныг тендерийн баримт бичигт тусган тодруулгын хариуг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр хүргүүлж байна. Үүнд:

Тодруулга 1:

-Төв аймгийн Лүн сумын 3.8 км газарт үерийн далангийн ажил гүйцэтгэх тендерийн шалгаруулалтын баримт бичиг, ажлын зурагтай танилцсан. Тухайн ажил нь БА-2.2 заалтаар гүйцэтгэхэд хангалттай байхад БА-3.2 заалт тусгасан;

Тодруулга 2:

-Үерийн далангийн ажилд БА-3.2 дахь заалтаар ажил гүйцэтгэхээр тавигдсан байна. Уг ажлыг гүйцэтгэх зураг, төсөвт БА-2.2 заалтаар гүйцэтгэх боломжтой байна;

Тодруулга 3:

-Усны барилга байгууламжийн инженер нь гэрээт ажилтан байж болох уу;

-БА-3.2 усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил гэх нөхцөлтэй "Барилга, хот байгуулалтын яам"-ны тусгай зөвшөөрлийн шаардлагыг "Зам, тээврийн хөгжлийн яам"-ны 2.8.2.3 бүх төрлийн гүүр, тунель, үерийн хамгаалалтын далан барих гэх нөхцөлтэй авто зам, замын байгууламжийг барих, засварлах тусгай зөвшөөрлөөр хангаж болох эсэх талаар уг шаардагууд дээр тодруулга гаргаж өгнө үү.

Тендер сонирхогчдод тодруулга гаргасан нь:

1.Үерийн далан байгуулах ажлын зурагт өгөгдсөн барилгын ажил гүйцэтгэх техникийн шаардлагад барилга угсралтын ажлыг усны барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэхээр тодорхойлогдсон тул Барилга, хот байгуулалтын яамны БА-2.2, БА-3.2 дахь "Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл шинэчлэлийн ажил" заалтаар гүйцэтгэх боломжтой харин тус ажлын магадлал хийгдсэн зураг, төсөвт "Зам, тээврийн хөгжлийн яам"-ны 2.8.2.3 бүх төрлийн гүүр, тунель, үерийн хамгаалалтын далан барих тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий этгээд гүйцэтгэж болох талаар тодорхойлж заагаагүй байна.

2. Усны барилга байгууламжийн инженер нь гэрээт ажилтан байж болохгүй уг ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Барилга, хот байгуулалтын яамнаас олгогддог БА-2.2, БА-3.2 заалтууд нь Усны барилга байгууламжийн инженер шаарддаг, усны барилга байгууламжийн инженертэй байж тусгай зөвшөөрөл олгогддог тул тус инженер техникийн ажилтан нь байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай.

Тендерт оролцогчдын тодруулгатай холбоотойгоор тендерийн өгөгдлийн хүснэгтийн холбогдох хэсэгт өөрчлөлт хийгдсэн болохыг мэдэгдье.

ДАРГА



Б.НАСАНЖАРГАЛ